ТӨРИЙН АУДИТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:СНАГ-2025/34/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхжин
Утас: 261628 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн " Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал:С.Тунгалаг
Утас: 99061771, 7000177

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан 7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан 8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 9
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл 11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 12
3.1 Монголын цахилгаан холбоо ХК, түүний үйл ажиллагаа 12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт 13
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл 13
4. АУДИТЫН ТАЙЛАН 15
4.1 Ерөнхий зүйл 15
4.2 Материаллаг байдал 15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 17
5.1 Албан шаардлага 18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 20
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл 20
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 21
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
СХЭУГ	Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар
СЯ	Сангийн яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын их хурал
УУББ	Уул уурхайн бүтээгдэхүүний бирж
ХК	Хувьцаат компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮ	Хяналт- шинжилгээ, үнэлгээ
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
МЦХ	Монголын цахилгаан холбоо

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЧИНБАТ ТАНАА

2025.04.07 № 07/1398
танай _____-ны №_____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 1,666.5 сая төгрөг, цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг зөрүүтэй бүртгэж тайлагнасан 164.5 сая төгрөг, Нягтлан бодох бүртгэлд ажил, гүйлгээ бүртгээгүй 0.9 сая төгрөг зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,839.8 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,574.5 сая төгрөгөөр давсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 зүйлийн 11.8, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлын онцлон тэмдэглэсэн хэсэг

Монголын хөрөнгийн биржээр 83 өдөр 29,555 ширхэг нийт 14.8 сая төгрөгийн хувьцааны арилжаа явагдсан байна.

Z:\Yawsan_Bichig\2025\0407 SNAG-9.Docx

1525071509

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 210 дугаар тогтоолоор 2024 оны цэвэр ашгийн 77.9 хувь буюу 25.8 сая төгрөгийг ногдол ашигт хуваарилж, нэгж хувьцаанд 1 (нэг) төгрөг байхаар тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 192 дугаар тогтоолын 4-т Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Жигжиджавын гудамжинд байрлалтай 779 м.кв талбайтай, эрхийн улсын бүртгэлийн Э-2202005542 дугаартай, 4,627.3 сая төгрөгийн зах зээлийн үнэ бүхий газрыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-д төлөх богино хугацаат өр төлбөрт шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 203 дугаар тогтоолын 1-т компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хангалттай, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлэхэд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2025\0407 SNAG-9.Docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12 сарын 31
1	**Хөрөнгө**		
1.1	**Эргэлтийн хөрөнгө**		
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	751,782,919.75	484,906,162.75
1.1.2	Дансны авлага	3,945,046,395.00	6,847,874,274.85
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	3,223,219.87	11,690,176.25
1.1.4	Бусад авлага	1,867,954,083.17	1,587,390,879.12
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	1,500,000,000.00	-
1.1.6	Бараа материал	3,437,925,422.78	3,212,389,509.63
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,303,367,881.95	3,788,503,981.63
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**13,809,299,922.52**	**15,932,754,984.23**
1.2	**Эргэлтийн бус хөрөнгө**		
1.2.1	Үндсэн хөрөнгө	38,857,706,205.67	38,303,984,017.64
1.2.2	Биет бус хөрөнгө	15,193,688,594.77	10,024,622,061.59
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	155,212,100.00	166,530,700.63
1.2.10	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**54,206,606,900.44**	**48,495,136,779.86**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**68,015,906,822.96**	**64,427,891,764.09**
2	**Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч**		
2.1	**Өр төлбөр**		
2.1.1	**Богино хугацаат өр төлбөр**		
2.1.1.1	Дансны өглөг	6,109,423,314.99	6,288,431,914.57
2.1.1.3	Татварын өр	835,291,129.79	1,860,381,683.90
2.1.1.4	НДШ-ийн өглөг	428,662.48	184,432.26
2.1.1.6	Хүүний өглөг	270,592,190.16	
2.1.1.7	Ноогдол ашгийн өглөг	146,169,613.66	154,365,413.66
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	468,260,758.38	366,847,275.06
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,734,177,481.75	4,050,346,519.30
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**10,564,343,151.21**	**12,720,557,238.75**
2.1.2	**Урт хугацаат өр төлбөр**		
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,209,000,000.00	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,503,973,693.32	1,503,973,693.32
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	4,370,849,753.20	1,265,024,580.52
2.1.2.6	**Урт хугацаат өр төлбөрийн дүн**	**7,083,823,446.52**	**2,768,998,273.84**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**17,648,166,597.73**	**15,489,555,512.59**
2.3	**Эздийн өмч**		
2.3.1	Өмч: - төрийн	2,449,928,700.00	2,449,928,700.00
2.3.2	- хувийн	137,098,889.00	137,098,889.00
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,088,188,462.23	14,088,188,462.23
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	8,247,270,172.39	8,247,270,172.39
2.3.9	Хуримтлагдсан ашиг	25,445,254,001.61	24,015,850,027.88
2.3.11	**Эзэмшигчдийн өмчийн дүн**	**50,367,740,225.23**	**48,938,336,251.50**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**68,015,906,822.96**	**64,427,891,764.09**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12 сарын 31
1	**Борлуулалтын орлого /цэвэр/**	**18,938,223,103.01**	**25,097,594,083.63**
2	Борлуулалтын өртөг	(14,704,824,592.67)	(19,628,981,359.43)
3	**Нийт ашиг (алдагдал)**	**4,233,398,510.34**	**5,468,612,724.20**
4	Түрээсийн орлого	649,693,435.66	534,370,170.83
5	Хүүгийн орлого	164,718,433.72	68,102,080.28
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	514,144,459.22	164,732,631.72
9	Борлуулалт, маркетингийн зардал	(1,448,188,458.72)	(1,123,680,670.16)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(2,979,884,438.96)	(3,057,167,663.25)
11	Санхүүгийн зардал	(225,432,665.67)	(1,185,265,879.95)
12	Бусад зардал	(869,065,134.37)	(833,192,215.99)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(1,994,038.18)	(371,088.35)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	78,681,818.18	71,842,077.80
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**	**116,071,921.22**	**107,982,167.13**
19	Орлогын татварын зардал	(87,214,478.89)	(49,306,373.81)
20	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**28,857,442.33**	**58,675,793.32**
21	**Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)**	-	-
22	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**28,857,442.33**	**58,675,793.32**
23	**Бусад дэлгэрэнгүй орлого**	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	8,840,633,417.13	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	**Орлогын нийт дүн**	**8,869,490,859.46**	**58,675,793.32**
25	**Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)**	**8,869,490,859.46**	**58,675,793.32**

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	**2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл**	**2,587,027,589.00**	**5,247,555,045.10**	**8,247,270,172.39**	**20,586,339,619.90**	**36,668,192,426.39**
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	4,830,056,939.38	4,830,056,939.38
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	28,857,442.33	28,857,442.33
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	8,840,633,417.13	-	-	8,840,633,417.13
1	**2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл**	**2,587,027,589.00**	**14,088,188,462.23**	**8,247,270,172.39**	**25,445,254,001.61**	**50,367,740,225.23**
2	НББ--ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(1,488,079,767.05)	(1,488,079,767.05)
3	**Залруулсан үлдэгдэл**	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	58,675,793.32	58,675,793.32
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-		-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	**2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл**	**2,587,027,589.00**	**14,088,188,462.23**	**8,247,270,172.39**	**24,015,850,027.88**	**48,938,336,251.50**

ТОРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЭШГААРЛАЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12 сарын 31
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
1.1	Мөнгөн орлогын дүн(+)	18,460,291,583.54	23,578,409,128.05
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	16,311,807,883.10	17,064,339,500.91
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	872,778.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,148,483,700.44	6,513,196,849.14
1.2	Мөнгөн зарлагын дүн(-)	(17,049,666,170.33)	(20,546,346,736.77)
1.2.1	Ажиллагчдад төлсөн	(5,843,769,120.81)	(6,647,911,351.92)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(1,667,772,652.46)	(1,880,547,081.74)
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	(3,454,040,774.14)	(3,929,480,951.29)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	(3,085,791,663.03)	(3,048,465,985.56)
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(428,487,596.34)	(435,529,071.33)
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		(1,018,172,729.27)
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	(1,252,536,843.21)	(1,357,350,804.84)
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	(26,859,912.27)	(38,473,348.00)
1.2.9	Бусад мөнгөн зарлага	(1,290,407,608.07)	(2,190,415,412.82)
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**1,410,625,413.21**	**3,032,062,391.28**
2	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
2.1	Мөнгөн орлогын дүн(+)	243,137,265.04	13,171,182.68
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	221,881,363.64	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	13,172,100.00	12,599,002.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	8,083,801.40	572,180.68
2.1.7	Хүлээн авсан ноогдол ашиг		
2.1.8	Бусад орлого.		
2.2	Мөнгөн зарлагын дүн(-)	(1,210,066,103.01)	(3,245,886,254.00)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(1,210,066,103.01)	(3,166,508,854.00)
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	(79,377,400.00)
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад зарлага.	-	-
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(966,928,837.97)**	**(3,232,715,071.32)**
3	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
3.1	Мөнгөн орлогын дүн(+)	659,786.87	1,560,696.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Валютын зөрүүний орлого	385,258.42	349,438.12

3.1.5	Бусад орлого	274,528.45	1,211,257.88
3.2	Мөнгөн зарлагын дүн(-)	(582,043.87)	(67,784,772.96)
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	(31,583,897.25)
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	(30,975,419.48)
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг		(5,066,470.00)
3.2.5	Валютын зөрүүний алдагдал	(554,573.87)	(46,099.86)
3.2.6	Бусад зарлага	(27,470.00)	(112,886.37)
3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**77,743.00**	**(66,224,076.96)**
4	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**443,774,318.24**	**(266,876,757.00)**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**308,008,601.51**	**751,782,919.75**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**751,782,919.75**	**484,906,162.75**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2024		Өөрчлөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлчилгээний орлого	26,580,356.1	26,926,267.7	345,911.6	101.3
	а/ Үндсэн үйл ажиллагаа	26,468,192.3	26,632,129.3	163,937.0	100.6
	б/ Үндсэн бус үйл ажиллагаа	112,163.8	294,138.4	181,974.6	262.2
2	**НИЙТ ОРЛОГО**	**26,580,356.1**	**26,926,267.7**	345,911.6	**101.3**
3	**НИЙТ ЗАРДАЛ**	**26,528,318.9**	**26,814,983.7**	286,664.8	**101.1**
	Үүнээс: Удирдлагын зардал	3,252,741.9	3,057,167.7	(195,574.2)	94.0
4	**Татварын өмнөх ашиг**	**52,037.2**	**111,284.0**	59,246.9	**213.9**
5	**Цэвэр ашиг /алдагдал/**	**46,833.4**	**58,675.8**	11,842.3	**125.3**
6	Төсвийн төлбөрт нийт дүн	3,752,600.0	3,237,897.9	(514,702.1)	86.3
7	Төрийн өмчийн ногдол ашигт	-	5,066.5	5,066.5	-
8	Нийт ажиллагсдын тоо	538	513	(25.0)	95.4
9	Нийт цалингийн сан	7,650,672.0	7,035,445.5	(615,226.5)	92.0
10	Нэг ажилчны дундаж цалин	1,185.0	1,089.8	(95.3)	92.0
13	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал	1.00	1.00	-	100.0
14	Хөрөнгө оруулалт	4,006,782.0	3,586,818.1	(419,963.9)	89.5
15	**НИЙТ АВЛАГА**	**9,259,483.1**	**8,446,955.3**	(812,527.8)	**91.2**
16	**НИЙТ ӨГЛӨГ**	**12,682,670.8**	**15,489,555.5**	2,806,884.8	**122.1**
	Үүнээс: Богино хугацаат өглөг	9,814,358.1	12,720,557.2	2,906,199.2	129.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Монголын цахилгаан холбоо ХК, түүний үйл ажиллагаа

Монголын цахилгаан холбоо ХК нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангаж, нийгэм эдийн засгийн үүрэг хариуцлагыг хүлээх зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааг явуулдаг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.
Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг компанийн дүрэмд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Иргэд бизнес, засгийн газрын болон бусад хэрэглэгчдэд өндөр чанартай, харилцаа холбооны бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх;
- Ашиг, орлогоо нэмэгдүүлэхийн тулд технологийн хөгжилтэй мөр зэрэгцэн ажиллах хувьцаа эзэмшигчдэдээ үр өгөөжтэй байх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монголын цахилгаан холбоо ХК-нь Компанийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Аудитын тухай хууль, Засгийн Газрын тусгай сангийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай, Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2022 оны 72 дугаар тогтоол зэрэг хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.
Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн аудитын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай;
- Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Мэдээлэл харилцаа холбооны салбарт мөрдөгдөж буй эрх зүйн актууд.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Монголын цахилгаан холбоо ХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/72 тоот тушаалаар компанийн үйл ажиллагаанд мөрдөх НББББББ-ийг баталсан байна.

Тус компанийн мөрдөж байгаа НББББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад зарим талаар нийцээгүй, үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,588.0 сая төгрөгөөр буюу 5.28 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	751,782.9	484,906.2	(266,876.8)
Дансны авлага	5,816,223.7	8,446,955.3	2,630,731.6
Бусад санхүүгийн хөрөнгө	1,500,000.0	-	(1,500,000.0)
Бараа материал	3,437,925.4	3,212,389.5	(225,535.9)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,303,367.9	3,788,504.0	1,485,136.1
Үндсэн хөрөнгө	54,206,606.9	48,495,136.8	(5,711,470.1)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**68,015,906.8**	**64,427,891.8**	**(3,588,015.1)**
Өр төлбөрийн нийт дүн	17,648,166.6	15,489,555.5	(2,158,611.1)
Эзэмшигчдийн өмчийн дүн	50,367,740.2	48,938,336.3	(1,429,404.0)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	**68,015,906.8**	**64,427,891.8**	**(3,588,015.1)**

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 266.8 сая төгрөгөөр буурсан нь банкин дах дансны үлдэгдэл 39.0 сая төгрөг, охин компанийн дансны үлдэгдэл 227.8 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан;
- Авлагын дансны үлдэгдэл 2,630.7 сая төгрөгөөр өссөн нь дансны авлага 2,341.4 сая төгрөг, татвар, НДШ-ийн авлага 8.5 сая төгрөгөөр тус тус өсөж, татвар, бусад авлага 280.6 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан;
- Бусад санхүүгийн хөрөнгө 1,500.0 сая төгрөгөөр буурсан нь хугацаат хадгаламжийн хугацаа дуусснаас шалтгаалсан.
- Бараа материалын дансны үлдэгдэл 225.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 14,749.3 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, үйл ажиллагаанд 14,974.8 сая төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,711.5 сая төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр 6,660.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 2024 оны 208 дугаар тогтоолын дагуу 5,810.4 сая хөрөнгө акталж, тайлант хугацаанд 7,327.2 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан;
- Өр төлбөрийн үлдэгдэл 2,158.6 сая төгрөгөөр буурсан нь богино хугацаат өр төлбөр 2,156.2 сая төгрөгөөр өсөж, урт хугацаат өр төлбөр 4,314.8 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан;
- Эздийн өмчийн дүн 1,429.4 сая төгрөгөөр буурсан нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга 1,488.1 сая төгрөгөөр буурч, тайлант хугацаанд 58.7 сая төгрөгийн ашигтай ажилласнаас шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Компанийн ТУЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор нийт орлогыг 33,547.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 32,655.6 сая төгрөгөөр, 903.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоож, хөрөнгө оруулалтын арга хэмжээг 9,363.1 сая төгрөгөөр баталж, зорилтот түвшний төлөвлөгөөнд 2024 оны 4 дүгээр тогтоолоор нийт орлогыг 26,468.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 26,528.3 сая төгрөгөөр, 46.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээг 4,006.8 сая төгрөгөөр тодотгол хийсэн байна.

Гүйцэтгэлээр 26,926.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 26,815.0 сая төгрөгийн зардал гарган, 111.3 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 26,926.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 345.9 сая төгрөг буюу 1.3 хувиар давсан нь үндсэн үйл ажиллагааны орлого 163.9 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 182.0 сая төгрөгөөр тус тус давсанаас шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 26,815.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 286.7 сая төгрөг буюу 1.1 хувиар илүү байна. Энэ нь үйл ажиллагааны өртөг 1,754.4 сая төгрөг, МТС сервис үндсэн ҮА-ны зардал 527.5 сая төгрөгөөр хэтэрч, үйл ажиллагааны зардал 1,587.2 сая төгрөгөөр хэмнэж, үндсэн бус үйл ажиллагааны зардлыг 421.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 36 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 3,586.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 58.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 11.8 сая төгрөгөөр илүү байгаа нь тайлант хугацаанд 286.7 сая төгрөгийн зардлыг илүү зарцуулсан, орлогын албан татварт 345.9 сая төгрөг илүү төлсөн нь нөлөөлжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 210 дугаар тогтоолоор 2024 оны цэвэр ашгийн 77.9 хувь буюу 25.8 сая төгрөгийг ногдол ашигт хуваарилж, нэгж хувьцаанд 1 (нэг) төгрөг байхаар тогтоосон байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Компанийн үйл ажиллагааг сайжруулах талаар авлага, өр төлбөрийн барагдуулалт, төлбөрийн баримт, газар эзэмших эрхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж чанарын хяналтын менежер С.Сожидмаа, компанийн захирал С.Тунгалаг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхжин, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Монголын цахилгаан холбоо ХК нь 2024 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн 1/89 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний нийт зардал 26,528.3 сая төгрөгөс 1.0 хувиар буюу 265.3 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд Эм Ти Си сервис ХХК-ийн захирлын тушаал шийдвэргүй 5 удаагийн ажил гүйлгээгээр 2.2 сая төгрөгийн хоолны зардлыг байгууллагаас төлсөн байна.
Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад." гэснийг тус тус мөрдөөгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Хоолны зардалд төлсөн 2.2 сая төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 2.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг шалгахад нийт 74 мэдээлэл байршуулахаас хугацаандаа оруулсан 34, оруулах мэдээлэл байхгүй 40 мэдээлэл байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд Монголын цахилгаан холбоо ХК нь 4,538.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааг нээлттэй болон харьцуулалтын аргаар зохион байгуулж, 3,983.9 мянган төгрөгийн гэрээ байгуулж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 2 улирлын санхүүгийн тайланг хамруулж, өмнөх аудитын хэрэгжилт, мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өр төлбөр, зардлын дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Шалгагдагч байгууллагад завсрын аудитаар 4,447.8 сая төгрөгийн 3 алдааг залруулах зөвлөмжийг асуудлын бүртгэлээр танилцуулан баталгаажуулсан ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж, үр дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 30,139.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 5.2 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 18,243.9 сая төгрөгийн 24 албан шаардлага хүргүүлснээс 21 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, 88.0 хувийн биелэлттэй, 3,497.6 сая төгрөгийн 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлснээс бүрэн биелүүлж, 8,392.7 сая төгрөгийн 7 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлж, нийт хэрэгжилт 91.7 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	4	5,235.60	4	5,235.60	100.0
Албан шаардлага	24	18,243,910.00	21	14,482,546.20	87.5
Зөвлөмж	7	8,392,676.40	7	8,392,676.40	100.0
Хариуцлага тооцох	1	3,497,632.20	1	3,497,632.20	100.0
Нийт дүн	**36**	**30,139,454.20**	**33**	**26,378,090.40**	**91.7**

Өмнөх аудитаар зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, нийгмийн даатгалын тайланд цалин хөлсийг буруу тайлагнасан албан шаардлагыг биелүүлээгүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар НББББББ, санхүүгийн программын шинэчлэл авлага өр төлбөрийн барагдуулалт, зэргийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,793.7 сая 6 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба Алдаа 41-д "Алдаа нь санхүүгийн тайлангийн элементүүдийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулга, болон тодруулгатай холбоотойгоор үүсэж болох юм. Санхүүгийн тайлан нь материаллаг алдааг эсвэл аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний тухайлсан тодорхой нэг толилуулгад хүрэхийн тулд санаатайгаар хийсэн материаллаг бус алдааг агуулж байвал СТОУС-тай үл нийцнэ.

Тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг. Гэвч заримдаа, материаллаг алдааг дараагийн тайлант үе хүртэл илрүүлж чаддаггүй бөгөөд тэдгээр өмнөх үеийн алдааг тухайн дараагийн тайлант үеийн санхүүгийн тайланд толилуулсан зэрэгцүүлэгдэх мэдээлэлд засварладаг." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй дараах ажил гүйлгээг аудитын явцад залруулаа. Үүнд:

- Тайлант оны 1-9 дүгээр саруудын цалингийн урьдчилгаа 1,555.2 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй, цалингийн өглөг дансанд хааж бүртгэснийг;
- Тайлант онд Эм Ти Си сервис ХХК-ийн бэлэн мөнгөний үлдэгдэл 1.0 сая төгрөгийг тооллого хийж баталгаажуулаагүйг;
- Тайлант онд Эм Ти Си сервис ХХК нь Монголын цахилгаан холбоо ТӨХК руу тоон гарын үсгийн 30% болох 28.8 сая төгрөгийг төлбөрийн баримтгүй шилжүүлсэн, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд татвараас хасагдахгүй зардлаар тайлагнасныг;
- Тайлант хугацаанд борлуулсан бүтээгдэхүүний өртгийг анхан шатны баримтгүйгээр 1,875.0 сая төгрөгөөр бууруулж урьдчилж төлсөн зардлыг нэмэгдүүлэн бүртгэснээс тайлант жилийн ашгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 48.1 сая төгрөгийг төлөхөөр тайлагнасныг;
- Тайлант онд цалин хөлсийг татварын цахим тайланд тайлагнахдаа 76 ажилтны цалин хөлсийг 220.2 сая төгрөгөөр дутуу, 48 ажилтны цалин хөлсийг 95.8 сая төгрөгөөр илүү, нийт 316.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг;
- Тайлант оны 1-9 дүгээр саруудын 1,017.6 сая төгрөгийн даатгуулагчаас суутгасан НДШ-ийг цалингийн зардал дансанд бүртгэж тайлагнасныг тус тус залруулав.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 1,839.8 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1,667.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 164.5 сая төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцуулах албан шаардлагыг тус бүр хүргүүлж, 7.8 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,839.8 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,574.5 сая төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Тайлант онд цалин хөлсийг нийгмийн даатгалын цахим тайланд тайлагнахдаа 147 ажилтны цалин хөлсийг 125.8 сая төгрөгөөр дутуу, 63 ажилтны цалин хөлсийг 38.8 сая мянган төгрөгөөр илүү, нийт 164.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгэр зүйлийн 21.1-д "Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө." гэж заасныг мөрдөөгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, нийгмийн даатгалын цахим системд алдаатай тайлагнасан буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд Голомт банкны пос машины орлогыг мөнгөн сууриар бүртгэсний улмаас орлогоос суутгасан 0.9 сая төгрөгийн банкны мерчантын шимтгэлийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 14 дүгээр зүйлийн 14.4.6-д "бүх зардал;" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Пос машины шимтгэлийн зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Монголын цахилгаан холбоо ХК-ны төв салбар нь 51 байгууллагын 715.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг, орон нутгийн салбар нь 1015 байгууллагын 721.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг, нийт 1,437.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "Эд хөрөнгийн

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

01 ТӨРИЙН АУДИТ ... ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлээгүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Монголын цахилгаан холбоо ХК-ны төв салбар нь 19 байгууллагын 162.7 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг, орон нутгийн салбар нь 500 байгууллагын 66.7 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлээгүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Илрүүлэлт:

Шалгагдагч байгууллага нь 18 төсөвт байгууллагад нийт 7.8 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т "Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна.", 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ." Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 10-т "Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах;" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөвт байгууллагад өгөх өр төлбөрийг тулган баталгаажуулах захидал, тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант оны 1-9 дүгээр саруудын цалингийн урьдчилгаа 1,555.2 сая төгрөгийг авлагаар бүртгэзгүй, цалингийн өглөг дансанд хааж бичсэн байна.	1	1,555,215.7	-	-	1	1,555,215.7	1	1,555,215.7	-	-	-	-
Тайлант онд Эм Ти Си сервис ХХК-ийн бэлэн мөнгөний үлдэгдэл 1.0 сая төгрөгийг тооллого хийж баталгаажуулаагүй байна.	1	1,000.0	1	1,000.0			1	1,000.0	-	-	-	-
Тайлант онд Эм Ти Си сервис ХХК нь Монголын цахилгаан холбоо ТӨХК руу тоон гарын үсгийн 30% болох 28.8 сая төгрөгийг төлбөрийн баримтгүй шилжүүлсэн, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд татвараас хасагдахгүй зардлаар тайлагнасан байна.	1	28,812.3	-	-	1	28,812.3	1	28,812.3	-	-	-	-
Тайлант хугацаанд борлуулсан бүтээгдэхүүний өртгийг анхан шатны баримтгүйгээр 1,875.0 сая төгрөгөөр бууруулж урьдчилж төлсөн зардлыг нэмэгдүүлэн бүртгэснээс тайлант жилийн ашгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 48.1 сая төгрөгийг төлөхөөр тайлагнасан байна.	1	1,875,000.0	1	1,875,000.0			1	1,875,000.0	-	-	-	-
Тайлант онд цалин хөлсийг татварын цахим тайланд тайлагнахдаа 76 ажилтны цалин хөлсийг 220.2 сая төгрөгөөр дутуу, 48 ажилтны цалин хөлсийг 95.8 сая төгрөгөөр илүү, нийт 316.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	316,013.4	-	-	1	316,013.4	1	316,013.4	-	-	-	-
Тайлант оны 1-9 дүгээр саруудын 1,017.6 сая төгрөгийн даатгуулагчаас суутгасан НДШ-ийг цалингийн зардал дансанд бүртгэж тайлагнасан байна.	1	1,017,631.4	-	-	1	1,017,631.4	1	1,017,631.4	-	-	-	-
Дүн	**6**	**4,793,672.9**	**2**	**1,876,000.0**	**4**	**2,917,672.9**	**6**	**4,793,672.9**	**-**	**-**	**-**	**-**

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд цалин хөлсийг нийгмийн даатгалын цахим тайланд тайлагнахдаа 147 ажилтны цалин хөлсийг 125.8 сая төгрөгөөр дутуу, 63 ажилтны цалин хөлсийг 38.8 сая мянган төгрөгөөр илүү, нийт 164.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	164,545.5	-	-	-	-			1	164,545.5	-	-
Тайлант онд Голомт банкны посоорх орлогыг мөнгөн сууриар бүртгэсний улмаас орлогоос суутгасан 0.9 сая төгрөгийн банкны мерчантын шимтгэлийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, орхигдуулсан байна.	1	893.1	-	-	1	893.1			-	-	-	-
Монголын цахилгаан холбоо ХК-ны төв салбар нь он 51 байгууллагын 715.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, орон нутгийн салбар нь 1015 байгууллагын 721.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна	1	1,437,225.7	-	-	1	1,437,225.7			-	-	-	-
Монголын цахилгаан холбоо ХК-ны төв салбар нь он 19 байгууллагын 162.7 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, орон нутгийн салбар нь 500 байгууллагын	1	229,309.1	-	-	1	229,309.1			-	-	-	-

162.7 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.												
Шалгагдагч байгууллага нь нийт 18 төсвийн байгууллагад 7.8 сая төгрөгийн өр төлбөртэй байна.	1	7,826.2	-	-	-	-	1	7,826.2	-	-	-	-
Дүн	**5**	**1,839,799.6**	**-**	**-**	**3**	**1,667,427.9**	**1**	**7,826.2**	**1**	**164,545.5**	**-**	**-**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЭЗГААР/ЛИТГЭЙ САНГИЙН ДҮГНЭЛТ

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант онд Эм Ти Си сервис ХХК-ийн захирлын тушаал шийдвэргүй 5 удаагийн ажил гүйлгээгээр 2.2 сая төгрөгийн хоолны зардлыг байгууллагаас төлсөн байна.	1	2,204.2	1	2,204.2	-	-	-	-
Дүн	**1**	**2,204.2**	**1**	**2,204.2**	**-**	**-**	**-**	**-**

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс